

Монгол улсын дипломат албаны үүсэл, хөгжлийн тухай

Л.Дашпүрэв*

Энэхүү өгүүлэлд Их Монгол Улс, 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд байгуулсан Богд Хаант Монгол Улс, 1921 оны Ардын хувьсгал, Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн өнөөг хүртэлх Монгол Улсын дипломат албаны түүхэн онцлог, гадаад харилцааны төв байгууллага болох Гадаад харилцааны яамны бүтэц, зохион байгуулалт, холбогдох газар, хэлтсийн чиг, үүрэг, эрх зүйн үндэслэл, элчин, консулын харилцаа, ДТГ-ууд, хүний нөөцийн бодлого зэргийг маш товчоор тусгав.

The article aims to briefly describe the particulars of the diplomatic service of Mongolia throughout the historic stages of the Great Mongol State, Bogdo Khaan's Mongolia after the 1911 national freedom revolution, Mongolia after the 1921 people's revolution, and transition to democracy and market economy until today. It also describes the structure, organization, functions of departments and divisions, as well as the legal status of the Ministry of Foreign Affairs, the central authority in charge of foreign relations, ambassadorial and consular relations, diplomatic representations and human resource policy.

Түлхүүр үгс: Дипломат алба, дипломат ажилтан, дипломт албаны менежмент

*Л.Дашпүрэв Монгол, Японы найрамдлын нийгэмлэгийн тэргүүн
Цахим хаяг: luvsandoodashpurev@yahoo.com

Key words: Diplomatic service, diplomatic servant, diplomatic service management

* * *



Айл, гэр бүлээс эхлээд улс орон хүртэл гадаад орчинтой хэрхэн зохицож, ажиллаж, амьдрах вэ? гэдэг нь маш өргөн хүрээтэй, түгээмэл ойлголт юм. Монгол Улсын дипломат алба ард түмэндээ хэдийчнээ нээлттэй байх тусам тэдний дэмжлэг, санал хүсэлтийг авч ажиллах ёстой билээ. Энэ удаа Монгол Улсын дипломат албаны үүсэл, хөгжлийн талаар товч боловч цөөн мөрөөр эрдэмтэд, судлаачид, энэ албыг сонирхогч хүмүүст толилуулахыг хичээлээ.

Их эзэн Чингис хаан маань “төрийн алтан аргамж” хэмээн болгоож айлдсан Монгол Улсын дипломат алба, түүний элчин харилцаа олон зуун жилийн түүхтэй билээ. Хүннү гүрэн хийгээд хүчирхэг мандсан Их Монгол Улсын үеэс өнөөг хүртэл өртөөчлөн Алтан гэрэгэ өвөртлөж, эх орон, ард түмнийхээ тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө амь бие үл хайрлан хүчин зүтгэж, тэмцэж ирсэн хэдэн арваад үе дамжсан уламжлалт дипломатуудтай орон юм.

Дэлхийн тэн хагастай тэнцэх өргөн уудам нутгийг хамарсан Их Монгол Улсын үед улс үндэстэн, ястан хоорондын хагарал тэмцлийг эв эеийг олох, яриа, хэлэлцээний дипломат урлаг, арга ухаанаар зохицуулах, төрийн ёс, уламжлал, шашин шүтлэгийг дээдлэх, хүмүүнлэгийн харилцаа, хэлхээ холбоог хүндлэн шилдэг хүмүүсийг сонгон шалгаруулж, төрийн түшээний хүндтэй албыг яс үндэс, хэргэм зэрэг, арьс өнгийг үл харгалзан хашуулах, шуудан харилцаа, худалдаа, наймааг өргөжүүлэх зэрэг олон асуудлыг чухалчлан үзэж, түүхэн ач холбогдолтой үүрэг гүйцэтгэж байсан юм гэдгийг түүхчид, судлаачид үнэлж, дүгнэсэн байдаг.

Чингэс хаан Их эзэнт гүрэнтэй эвтэй найртай байх уу, эс тэгэвээс байлдан дагуулж, энх амгаланг тогтоох уу гэдгийг шийдэхийн тулд бусад улс оронд элч, төлөөлөгч илгээж, байр суурийг нь судалж мэдэх, тэр ч байтугай дайсагнагч этгээдийн элч төлөөлөгчдөд хүртэл дипломат эрх ямбыг эдлүүлэхийг эрхэмлэн дээдэлж байсан нь түүхэн эх

сурвалжаас харагддаг. Чингэс хаан 1226 оны намар Тангудыг байлдан дагуулахын өмнөхөн ан хийж яваад мориноос унаж, бие чилээрхэсний дараа: “Тангуд иргэн биднийг зүрх алдаж харив хэмээнэ. Бид магад элч илгээж, элчийг мөн энэ Цоорхадад хүлээж, биеэ сувилж, үгийг нь мэдэж авч буцваас болно” хэмээн өгүүлжээ.¹

Алдарт эрдэмч, судлаач Жак Уэтэрфорд өөрийн бичсэн номондоо “ Чингэс хааны морьт цэргүүд 13 дугаар зууныг туулахдаа тив дэлхийн хил хязгааруудыг өөрчлөн шинэчилсэн юм. Тэд улс үндэстнүүдийг бүтээн бий болгож байлаа. Чингэс хааны үед улс орнуудад дипломатын болон худалдааны хэлхээ холбоо тогтсон нь өдгөө хадгалагдсаар байна. Тэр ихэс дээдсийн хэргэм зэрэг , эрх ямба, угсаа гарвал гэх мэт феодалын тогтолцоог халж, хувь хүний гавъяа зүтгэл, үнэнч шударгуу байдал, ололт амжилтад тулгуурладаг шинэ тогтолцоог бий болгосон юм. Торгон замын дагуу түүхэнд хамгийн том чөлөөт худалдааны бүсүүдийг бий болгож, өөрчилж хувиргасан юм. Тэр анх удаа олон улсын шуудангийн үйлчилгээг зохион байгуулсан юм. Тэр олон улсын хуулийг анхлан бий болгож, бүх хүн мөнх хөх тэнгэрийн зарлигт сөгдөн мөргөх болгосон. Ямар ч шашинтан байсан тэр эзэмшил нутагтаа шүтэж бишрэх эрх чөлөөг бүрэн хангасан юм. Тэр барьцаалахаас зайлсхийж, дайтаж байхдаа ч дайсагнагч этгээдийн элчин сайд, элч төлөөлөгчдөд хүртэл үл халдах дипломат дархан эрхийг эдлүүлэх эрхэм заншлыг хэвшүүлсэн юм” гэжээ.²

Гэвч Их эзэнт гүрний дотоод, гадаад хүчин зүйлээс улбаалан задралд орсон тэр үеэс 20 дугаар зууны эхэн үе хүртэл Монгол Улсын дипломат алба урт хугацааны хүнд бэрхшээлтэй замыг туулж иржээ. Харин 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд Богд Хаант Монгол Улсаа байгуулан тунхаглаж, туурга тусгаар улсаа дэлхийн томоохон гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх алхам хийж эхэлснээр манай улсын дипломат албаны орчин үеийн шастир түүхэн алтан хуудас нээгджээ.

Засгийн газрыг нь төрийн 5 яамтайгаар байгуулсаны нэг нь

¹Монголын Нууц Товчоо. Сонгомол эх. Арван хоёрдугаар бөлөг. 265. 177 дахь тал.

²Жак Уэтэрфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч ЧИНГЭС ХААН. УБ.: 2012 он.18-19 дахь тал.

ОЛОН УЛС СУДЛАЛ

Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яам байлаа. Тус яамны бүтцийн 3 хэлтсийн Өмнөдхэлтэс нь Дундадиргэн улстай холбогдох хэрэг зүйлийг эрхлэн явуулахаас гадна энэ улсын харьяат нар, худалдаачин, хувийн үйлдвэр эрхлэгчдийн асуудлыг зохицуулах, Умард хэлтэс нь Орос улстай харилцаж, Монгол Улсад оршин суугаа орос иргэдийн асуудлыг эрхлэх, Төв хэлтэс нь гадаад улсуудтай байгуулсан гэрээ, бичиг зураг, цахилгаан, чухал албан бичгийг хадгалах хийгээд Монгол Улсын яамдтай холбоо барьж, гадаад харилцааны асуудлыг зөвлөлдөн нийлж, зохицуулах зэрэг төрийн хэргийг эрхлэн шийддэг байжээ. Мөн яамны анхны тэргүүн сайдаар үндэсний эрх чөлөөний гарамгай удирдагч-эх оронч Түшээт Хан аймгийн жанжин засаг хошой Чин Ван М. Хандоржийг тохоон томилжээ.

Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны тухайн үеийн дипломат үйл ажиллагааны нэг чухал зорилт нь улс орныхоо тусгаар тогтнолыг хадгалан хамгаалах, юуны өмнө хоёр хөрш улсаар хүлээн зөвшөөрүүлэх явдал байв. Монгол, Оросын хооронд 1912 оны 11 дүгээр сарын 2-нд байгуулсан Найрамдал ба Хавсран тогтоосон худалдааны гэрээ нь Монгол Улс тусгаар тогтнолоо тунхаглан зарласанаас хойш Монгол Улсын олон улсын харилцаанд эзлэх статусыг тодорхойлоход хууль эрхийн анхны бодитой баримт бичиг болсон байдаг.³

Уг гэрээ, хэлэлцээрээр Монгол бол Эзэн хаантай, Засгийн газартай улс мөн. Монгол нь “өөртөө тогтнож, өөрөө эзэрхэх” ёс журамтай. Монгол нь өөрийн нутгаас Хятадын цэрэг ба эрх баригчдыг үлдэн гаргасан бөгөөд дахин өөрийн газарт Хятадын цэрэг ба нүүдлийн иргэдийг үл оруулах эрхтэй. Монгол нь Хятад болон бусад гадаад улстай хэлэлцээ хийж, гэрээ байгуулах эрх бүхий этгээд мөн гэдгийг Орос улсын Засгийн газар хүлээн зөвшөөрч, эдгээрийг “алдагдалгүй сахихад” цөм туслана гэж Орос Улс өөртөө үүрэг авсан байна. Эл гэрээ нь Монголын хувьд улс төрийн онцгой ач холбогдол агуулж, Монгол, Хятадын хооронд тогтож байсан урьдын харилцаанд цэг тавьсан төдийгүй шинэ Монгол Улсад дэлхийн аль ч улс оронтой харилцах эрхийг нээж өгсөн юм гэж олонхи судлаачид үздэг байна.

³О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монголын гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. УБ.:2002 он.

Монгол Улсын дипломат албаны салшгүй хэсэг консулын харилцаа ч мөн энэ үеэс улс хоорондын эрх зүйн шинжтэй болж, 1912 оны Монгол, Оросын найрамдлын гэрээ, 1915 оны Хиагтын 3 этгээдийн хэлэлцээнд Их Хүрээнд сууж байсан Оросын консул, Ерөнхий консул оролцож байжээ.

Монгол Улс хоёр хөршийн цэрэг, улс төрийн нөлөөнд арга буюу татагдан орж, тусгаар тогтнол, автономит эрх дархаа алдахад хүрч байсан түүхэн зурвас үед Орос оронд Октябрийн хувьсгал мандаж, Зөвлөлт Орос Улс шинээр төрж, түүний нөлөөгөөр 1921 онд ардын хувьсгал ялж, ардын Засгийн газрыг байгуулсан нь улс хоорондын шинэ харилцаанд Монгол Улсын дипломат алба жинхэнэ ёсоор цаашид хөгжин дэвшихэд чухал ач холбогдолтой болсон юм

Түүхийн хуудаснаас харахад, 1921 оны 7 дугаар сарын 10-нд Монгол Ардын Намын Төв Хорооны хурал болж, Ардын түр засгийн газрыг жинхэнэ Ардын засгийн газар болгож явуулах тухай хэлэлцээд: “Богдыг Монгол Улсын хэмжээт цаазат хаанаар өргөмжилж, автономитын засгийн газрын таван яамны бүх хэргийг Ардын Засгийн газарт шилжүүлэн, үндэсний хувьсгалт засаг төрийг байгуулсугай”²⁴ гэж уг хурлаас гаргасан шийдвэрт дурджээ. Ийнхүү нийслэл Хүрээнд мөн өдөр хэмжээт эрхт хаант Ардын засгийн газрыг Гадаад явдлын яам, Цэргийн яам, Сангийн яам, Дотоод яам, Шүүх яамны бүтэцтэй байгуулж байжээ. Гадаад явлын яам Богд хаант улсынхтай үндсэндээ адил яамны удирдлагаас гадна Ерөнхий хэлтэс, Умард хэлтэс, Өмнөд хэлтэс гэсэн 3 нэгжтэй үйл ажиллагаагаа эхэлжээ.

1921 онд Зөвлөлт Орос Улстай албан ёсны дипломат харилцаа тогтоож, 1922 онд Москва хотноо Элчин төлөөлөгчийн газраа нээж байсан нь Монгол Улсын дипломат албаны үйл ажиллагаанд тэмдэглэгдсэн анхны түүхэн үйл явдал байв.

Монгол Улсын дипломат алба 1921-1945 оны хооронд Тагнын Урианхай, Кызылийг эс тооцвол зөвхөн Зөвлөлт Орос Улстай гадаад харилцаагаа бэхжүүлж, өргөжүүлж ирсэн байна. Хятад, АНУ, Япон

²⁴ГХТА.ГЯЯ-ны түүх 1970.01.13. 438 хуудас бүхий материал.

ОЛОН УЛС СУДЛАЛ

зэрэг бусад хөрш, гуравдахь орнуудаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байсан, мөн өөрийн орны хоцрогдсон эдийн засгаа хөгжүүлэх, лам нарын бослого зэрэг ангийн тэмцлийн хурцадмал байдал, түүнээс улбаалсан хэмэгдүүлэлт, дайны хүнд жилүүд зэргээс хамааран ГЯЯ олигтой бэхжсэнгүй, байр орон сууцгүй, дотоод ажил ч бүрэн зүгшрээгүй, цөөн хэдэн ажилтан өдөр тутмын албыг залгуулах маягаар ажиллаж байжээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа буюу гадаад харилцаа өргөжих хандлага тавигдаж эхэлсэн 1946 оноос удирдах дээд байгууллага ГЯЯ-ны үйл ажиллагаа, цаашдын төлөв байдалд нухацтай дүгнэлт хийж, орон тоог нэмэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, аж ахуй санхүүгийн хувьд бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, яамыг жинхэнэ дипломат албаны дүр төрхтэй болгоход чиглэсэн тодорхой арга хэмжээ авчээ. Тухайлвал: ГЯЯ-ны ажлын зааврыг шинэчлэн мөрдөж, бүтэцэд Ёслолын хэлтэс, Хэрэг эрхлэх газар, шинэ хүчин, бичиг хэргийн тасаг шинээр байгуулагдаж, тус яамны болон гадаадад суугаа элчин сайд, элчин яамдын дипломат ажилтан нарын зэрэг цолыг анх удаа тогтоож, мэргэжлийн дипломатуудыг бэлтгэх үүднээс Москвагийн олон улсын харилцааны дээд сургуульд оюутан илгээх болсон байна. ГЯЯ орон байрны хувьд ч бэхжиж, тэр үед хамгийн түрүүнд ашиглалтанд орсон / одоогийн ХБНГУ-ын ЭСЯ / байранд нүүж орсон бөгөөд 1947 оноос өөрийн гэсэн шинэ байртай / одоогийн байгаа / болж, өнөөг хүртэл энд албан ажлаа явуулж байна.

БНМАУ 1948 онд БНАСАУ-тай, 1949 онд БНХАУ-тай дипломат харилцаа тогтоож, ЭСЯ-даа нээх болсон, мөн Европын социалист орнуудтай 1950 онд дипломат харилцаа тогтоосоноос хойш эдгээр орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж, цаашид ч олон салбарыг хамрах болжээ. ГЯЯ-ны сайд Н. Лхамсүрэн 1950 оны үйл ажиллагааны тайлан илтгэлдээ дурдахдаа Маршал Чойлбалсан 1950 оны 3 дугаар сарын 6-нд хэлсэн үгэндээ: “Манай гадаад харилцаа өргөжиж байгаа явдлаас үндэслэн цаашид ГЯЯ улам өргөжих учиртай гэж заасныг үндэслэж, МАХН-ын Төв Хороо, Засгийн газар БНМАУ-ын гадаад харилцаа эрс өргөжиж байгааг харгалзан тус яамны зохион

байгуулалт, орон тоог нэмэгдүүлэв” гэжээ.⁵ Ийнхүү ГЯЯ-ны орон тоо 1951 онд 61 байсныг 120 болгон нэмэгдүүлжээ.

1962 оны байдлаар ГЯЯ-ны бүтэц, зохион байгуулалтад Олон улсын байгууллага, Гэрээ, эрхийн хэлтэс, Хэвлэл, мэдээллийн хэлтэс, Консулын хэлтэс, Санхүүгийн хэлтэс, Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс шинээр байгуулагдан цар хүрээ нь өргөжсөөр байв.

Монгол Улсын дипломат албаны боловсон хүчнийг бэлтгэхэд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, ГЯЯ-ны дэргэдэх Дипломатын Академи чухал үүрэг гүйцэтгэж, одоо ч манай оюутнууд, дипломатууд суралцаар байна.

1946-2009 онд ГЯЯ-ны нэр дээр Москвагийн ОУХДС-ийг манай 200 шахам иргэн, Дипломатын Академийг 100 гаруй хүн төгсч ирээд, тэд Монгол Улсын гадаад бодлогын зорилтуудыг боловсруулах, хэрэгжүүлэхэд хүчин зүтгэж иржээ. Хуучин социалист орнууд гэгдэж байсан Болгар, БНАГУ, Югослав, Унгар зэрэг орны их, дээд сургуулиудад гадаад харилцааны чиглэлээр 50 шахам хүн төгссөн байна.

Дипломат ажилтан нараар тангараг өргүүлдэг журмыг 1965 оноос эхлэн өнөөг хүртэл мөрдөж байна.

Монгол Улсын дипломат албаны олон улсын эрх зүйн орчинг бүрдүүлэх, чадавхийг бэхжүүлэхэд дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенц, 1963 оны Консулын харилцааны тухай Венийн конвенц чухал ач холбогдолтой бөгөөд 1968 онд ГЯЯ-ны сайдын тушаалаар батлагдсан Дипломат төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны тухай ерөнхий заавар, ГЯЯ-ны хэмжээнд ажлын төлөвлөгөө зохиох, дүгнэх, тайлан илтгэл гаргах тухай заавар, Гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын бичиг хэрэг хөтлөх тухай заавар, ГЯЯ, дипломат төлөөлөгчийн газруудын дипломат шуудангийн тухай заавар, Мэдээллийн ажлыг зохион байгуулах тухай заавар зэрэг нь тус яамны мөрдөж буй өнөөгийн дотоод ажлын заавар, журмын эхлэлийг тавьсан гэж үзэх үндэстэй юм.

⁵ГХТА.ф1.д2.хн 65

ОЛОН УЛС СУДЛАЛ

Олон улсын байдал, дотоод дахь ардчилал, шинэчлэлийн үйл явцтай уялдан 1980-аад оны дунд болон 90-ээд оны эхэн үеэс Монгол Улсын гадаад бодлогод төдийгүй, ГЯЯ-ны бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого зэрэг дипломат албанд өөрчлөлт, шинэчлэл эрчимтэй явагдав. 1990 оны 6 дугаар сард хийсэн ГЯЯ-ны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр төв аппарат удирдлагын хэсгээс гадна 11 нэгжтэй болж, нийт орон тоо 118 хэвээр үлдсэн байна. Дээд байгууллагын шийдвэрээр мөн онд ГЯЯ-ыг татан буулгаж, Гадаад харилцааны яамыг шинээр байгуулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 175 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн ерөнхий хөтөлбөрийг зөвшөөрсөн байна. Энэхүү хөтөлбөр ГХЯ-ны үйл ажиллагааны стратеги, зорилт, бүтцийн ерөнхий тогтолцоо, түүний үндсэн чиглэл, үүргийг нилээд оновчтой тодорхойлсон чухал баримт бичиг болсон бөгөөд удаа дараагийн сонгуулийн дүнд бий болсон УИХ, Засгийн газар уг баримт бичгийг боловсронгуй болгох замаар хэрэгжүүлж иржээ.

Өнөөгийн Гадаад харилцааны яам / ГХЯ / нь төр, засгийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрхэлдэг төрийн захиргааны төв байгууллага мөн.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа Монгол Улсын үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын дипломат албаны тухай хууль, холбогдох бусад хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг мөрдлөг болгодог байна.

- ГХЯ-ны эрхлэх ажлын хүрээнд доор дурьдсан үндсэн чиглэлүүд орж байна. Үүнд:
- Хөрш зэргэлдээ болон гадаад улс оронтой харилцах, бүс нутагт явуулах улс төрийн гадаад бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх,
- НҮБ болон олон улсын бусад байгууллагатай харилцах, тэдгээрт Монгол Улсыг төлөөлөн үйл ажиллагаанд нь оролцох,
- Олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, олон этгээдийн гэрээнд

- нэгдэн орохтой холбогдсон ажил гүйцэтгэх,
- Олон улсын болон бүс нутгийн байдал, нэн ялангуяа бусад улсын гадаад бодлогын тухай цаг үеийн мэдээгээр төр, засгийн газрыг байнга хангаж байх, олон улсын харилцааны онцлог асуудалд дүн шинжилгээ хийж, энэ талаарх засгийн газрын байр суурийг боловсруулан зохих хэлбэрээр илэрхийлэх,
 - Монгол Улсын болон гадаад улс төр, засгийн тэргүүний айлчлалын бэлтгэлийг хангаж хэрэгжүүлэх,
 - Монгол Улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн гадаад бодлогыг боловсруулах, түүнийг хоёр болон олон талын хүрээнд хэрэгжүүлэх асуудлаар санал дүгнэлт гаргах, гадаад улс орон, олон улсын байгууллагаас зээл тусламж авах хүсэлтийг засгийн газрын өмнөөс тавьж шийдвэрлүүлэх талаар бусад яам газруудтай хамтран ажиллах,
 - Гадаад орон, олон улсын байгууллагуудтай эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах засгийн газар хоорондын комисс, хороодын хурлын бэлтгэлийг хангаж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оролцох,
 - Монгол Улсын хилийн шугам, хилийн дэглэмийг тогтоох ажилд оролцох, хилийн шугамыг холбогдох улстай хамтран шалгах ажлыг зохицуулах,
 - Дипломат албаны мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөцийн бодлогыг боловсруулах, тэднийг бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх, давтан сургах,
 - Монгол Улсын дипломат болон консулын төлөөлөгчдийн газруудыг удирдлагаар хангах,
 - Монгол Улсын консулын албаны ажлыг эрхлэн гүйцэтгэж, гадаадад оршин суугаа монгол иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах,
 - Дипломат болон консулын төлөөлөгчдийн газруудын тэргүүнийг томилох, эгүүлэн татах талаар саналаа удирдах дээд байгууллагад оруулж, шийдвэрлүүлэх,
 - Дипломат болон консулын төлөөлөгчдийн газруудын байршлыг зохистой тогтоох зэрэг зүйл багтсан байна.⁶

⁶Монгол Улсын Гадаад харилцааны яам 1911-2011. УБ.: 2011 он.153-154 дэх тал.

ОЛОН УЛС СУДЛАЛ

Гадаад харилцааны яамны зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор:

- Бодлого төлөвлөлт, судалгааны газар /мэдээлэл, гадаад сурталчилгааны хэлтэстэй/, Хөрш орнуудын газар /хил, хилийн боомтын хэлтэстэй/, Ази, Номхон далайн орнуудын газар, Европ, Ойрхи Дорнодын газар, Америк, Африкийн газар, Олон улсын байгууллагын газар, Төрийн захиргааны удирдлагын газар /санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, мэдээллийн технологийн тасаг, гадаад харилцааны төв архивтай/, Гэрээ эрхзүйн газар, Консулын газар, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Дипломат ёслолын газар гэсэн нэгжтэйгээр батлагдан 137 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

ГХЯ-ны удирдах бүрэлдэхүүн нь сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, сайдын зөвлөлөөс бүрддэг бөгөөд тус яамыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд тэргүүлэн ажилладаг.

Олон улсын даяарчлалын шинэ эрин үед орон бүр өөрийн дипломат албыг улам боловсронгуй болгож, ялангуяа арга барил, менежментийг нь сайжруулах явдал зүй ёсоор тавигдаж байгаа юм. Монгол Улс дипломат албаны олон зуун жилийн түүхтэй орон тул цаашид Монгол Улсын дипломат албыг илүү шинжлэх ухааны үндэслэлтэй, салбар судалгаануудыг орчин үетэй холбон хийх нь зүйтэй гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Монголын Нууц Товчоо. Сонгомол эх
2. Жак Уэтэрфорд “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч ЧИНГЭС ХААН. УБ.: 2012 он
3. Ж. Бор. “Монгол хийгээд Евразийн дипломат шастир” 4 боть, 2006 он.
4. О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос,

Монгол улсын дипломат албаны үүсэл, хөгжлийн тухай

Монголын гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. УБ.:2002 он.

5. ГХЯ. “Монгол Улсын Гадаад харилцааны зуун жилийн түүхийн тойм” 2011 он
6. ГХЯ. “Монгол Улсын Гадаад харилцааны яам 1911-2011” 2011 он
7. ГХЯ. “Монгол Улсаас хилийн чанад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд” 2011 он